

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДУА-2022/30-10-ШТА-НА

Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох
Утас: 70592439,
Аудитын менежер Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn
Ахлах аудитор Т.Батсайхан
Аудитор Л.Уранбилэг
Аудитор Г.Самданцоодол
Утас: 70593208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-8
	Дүрслэлийн товч	9
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<u>Бүлэг 1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, бүрдсэн ч аймгийн бодлогын хэрэгжилт хангалтгүй байна</u>	10
Аудитын менежер Х.Наранцацрал	А.1 Аймгийн хөгжлийн бодлогын урт дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.	10-14
Ахлах аудитор Т.Батсайхан	А.2 Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, төлбөр түүнтэй холбогдох харилцааг тусгаж дүгнэсэн ч бодит үр гаргаагүй байна.	15-16
Аудитор Л.Уранбилэг	<u>БҮЛЭГ 2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль журмын дагуу хэрэгжээгүй байна.</u>	17
Г.Самданцоодол	Б.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөхгүй байна.	17-23
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Б.2 Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтыг хуулийн дагуу зарцуулаагүй байна.	23-28
	<u>БҮЛЭГ 3. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавиагүй, мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллаагүй байна.</u>	28
	В.1 Хуулийн хэрэгжилтэд хяналт тавиагүй, мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллаагүй байна.	28-29
ХАЯГ:	Дүгнэлт	29-30
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 213 тоот	Зөвлөмж	30-31
2023 оны 06 дугаар сар	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	32-33



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 11/13

Мандалговь

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан / ДУА-2023/30-10-ШТА-НА / -г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (албан шаардлага)-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Нийцлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /С.Од-Эрдэнэ/, Засаг дарга /Ц.Мөнхбат/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Н.Гантулга / зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2023 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын гуравдугаар нэгжийн ахлах аудитор /Т.Батсайхан/ аудитор /Л.Уранбилэг/, /Г.Самданцоодол/ нарт үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

ТОВЧИЛСОН ҮГС

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
АЗДҮАХ	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БОХНСС	Байгал орчныг хамгаалах, нөхөн сэргээх сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ОНТ	Орон нутгийн төсөв
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
УТ	Улсын төсөв
УГГХДТСГЗ	Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ЭЗНХҮЧ	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

<i>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</i>	Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.
<i>Аудитын зорилго, зорилт:</i>	“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд: • Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх; • Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх; • Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх.
<i>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:</i>	Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: • Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль; • Хууль тогтоомжийн тухай хууль; • Байгаль орчныг хамгаалах тухай хууль; • Ойн тухай хууль; • Усны тухай хууль; • Амьтны тухай хууль; • Газрын тухай хууль; • Байгалийн ургамлын тухай хууль; • Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; • Төсвийн тухай хууль; • Шилэн дансны тухай хууль; • Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд

<i>Аудитын хамарсан хүрээ:</i> <i>Аудитын арга зүй:</i> <i>Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа</i>	зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” • Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” • “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021 оноос 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол) Холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актууд Аудитад аймгийн ИТХ, ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтсийн холбогдох үйл ажиллагааг хамруулж, хуулийн хэрэгжилтийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа шинжилгээг хамрууллаа. Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан. Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Л.Уранбилэг, Г.Самданцоодол нар тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу
--	---

ҮНДСЭН
МЭДЭЭЛЭЛ

2023 оны 05 сарын 05-ны өдрөөс 06 сарын 16-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Дундговь аймаг нь Монгол Улсын нийт газар нутгийн 4.5%-ийг эзэлдэг. Дундговь аймаг ус зүйн сүлжээгээр Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар, Онги-Таац голын сав газарт хамаардаг. Тус аймаг 2020 оны тооллогоор гол горхи 1, булаг шанд 121, рашаан 6, нуур тойром 17, худаг уст цэг 3663 бүртгэгджээ. Энэ мужид олон жилийн гадаргын усны урсац 0.5-0.7 мм/жил байдаг байна. Гадаргын усны эх үүсвэрийг хэдийгээр малын усан хангамж, унд ахуйд бага зэрэг хэрэглэж байгаа боловч, гадаргын усны ашиглах боломжит нөөц байхгүй гэж үздэг. Дундговь аймагт нийт 21 усны орд газар байгаагаас Мандалговь хотын Олгойн говьд байрлах 2 усан хангамжийн газрын доорх усны ордод 1986 онд ашиглалтын нөөц баялгийн үнэлгээ хийгдсэн байна.

Дундговь аймгийн Өлзийт суманд Заган ойн Улсын тусгай хамгаалалттай бүс нутагтай. Заган ойн сангийн нийт талбай 32759 га талбай байгаагаас 16852 га буюу 51.4 хувь нь ойгоор бүрхэгдсэн талбай, 15907 га буюу 48.6 хувь нь ойгоор бүрхэгдээгүй талбай эзэлж байна. Ойгоор бүрхэгдсэн талбайн 16793 га буюу 99.64 хувийг байгалийн заган ой 16 га буюу 0.09 хувийг сөөг, 43 га буюу 0.25 хувийг тармаг заг, ойгоор бүрхэгдээгүй талбайн 14953 га буюу 94.0 хувийг тармаг заг, 954 га буюу 6.0 хувийг ойжих талбай тус тус эзэлж байна.

Шороон шуурганы давтагдал жилээс жилд нэмэгдэж 2016 оноос 2020 он гэхэд даруй 182-оор, 15 м/с-ээс дээш хүчтэй салхитай өдрийн тоо 3 дахин, нөөлөг салхитай өдрийн тоо 4 дахин өссөн байна. Аймгийн нийт нутгийн 90 гаруй хувьд цөлжилт эрчимтэй явагдаж байна.


Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2018 онд аймгийн нутаг дэвсгэр дээр ургадаг ургамлын ерөнхий судалгааг хийж тодорхойлсон бөгөөд Дундговь аймагт 39 овогт хамаарах 123 төрлийн 202 зүйлийн ургамал хээрийн судалгаагаар бүртгэгдсэн мөн 20 овгийн 28 төрлийн 37 зүйл ургамлын тархац, 9 зүйл ургамлын нөөцийн судалгаа хийгдсэн байна.

Агнуур зохион байгуулалтын судалгааг 5 жил тутамд хийдэг бөгөөд 2017 онд судалгаа хийгдсэн 2023 онд шинээр судалгаа хийхээр төлөвлөөд гүйцэтгэлийн шатанд байна. 2017 оны судалгаагаар аймгийн нутаг дэвсгэрт цагаан зээр, хар сүүлт, аргаль хонь, янгир ямаа, тарвага болон бусад хөхтөн амьтдын нөөцийг судалж тогтоосон байна. Судалгааны дүнгээр угалз агнуурын бүс

Аудитын дүн	байгуулах боломжтой нутаг Өлзийт, Баянжаргалан, Дэлгэрцогт, Адаацаг сумдад, тэх агнуурын бүс байгуулах боломжтой газар нь Өлзийт, Сайхан-Овоо сум, тарвага агнуурын бүс байгуулах боломжтой газар Баянжаргалан сумын нутагт байхаар үнэлгээ хийгдсэн байна. Дундговь аймгийн хэмжээнд сүүлийн дөрвөн жилд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2,121.6 сая төгрөг батлагдсан байна. Гүйцэтгэлээр 3,522.4 сая төгрөгийг төвлөрүүлж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сангийн зардалд 604.3 сая төгрөгийг төлөвлөж, 483.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Аудитаар нийт 106.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 106.6 сая төгрөгийн 2 албан шаардлага, хариуцлага тооцуулах албан шаардлага 1, АИТХ-д-1, Аймгийн Засаг даргад-3, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт-1 нийт 5 зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.
---------------------------	---

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Бодлогын баримт бичгийн төлөвлөлт	
Хүснэгт 2	Ойн менежментийн мастер төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх	
Хүснэгт 3	Аймгийн Засаг даргын салбарын сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт	
Хүснэгт 4	Нөөц тогтоогдсон газрын доорх цэнгэг усны ордууд (Умард ГГХДТСГЗ 2020 оны усны бүртгэл тооллого)	
Хүснэгт 5	Ан агнуурын санал батлагдсан тоо хэмжээ	
Хүснэгт 6	Байгалийн нөөц ашигласны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	
Хүснэгт 7	Усны төлбөрийн орлогын төлөвлөгөө, ногдуулалт гүйцэтгэл	
Хүснэгт 8	Ан амьтны төлбөрийн орлогын төлөвлөгөө, ногдуулалт, гүйцэтгэл	
Хүснэгт 9	Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө, ногдуулалт, гүйцэтгэл	
Хүснэгт 10	Ан амьтны төлбөрийн орлогын гүйцэтгэл батлагдсан зардал	
Хүснэгт 11	Газрын төлбөрийн орлогын гүйцэтгэл батлагдсан зардал	
Хүснэгт 12	Усны төлбөрийн орлогын гүйцэтгэл батлагдсан зардал	
Хүснэгт 13	Ан амьтны төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт	
Хүснэгт 14	Усны төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт	
Хүснэгт 15	Газрын төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт	



БҮЛЭГ 1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, бүрдсэн ч аймгийн бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.

А.1 Аймгийн хөгжлийн бодлогын урт дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

А.1.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь холбогдох хууль тогтоомж бусад эрх зүйн орчин бүрдсэн байна.



Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6 дугаар бүлэгт “Ногоон хөгжил” зорилгын хүрээнд 4 үндсэн зорилт дэвшүүлсэн байна. Ногоон хөгжил зорилтын хүрээнд Дундговь аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд дараах байдлаар тусгасан байна. (Хүснэгт 1)

Хүснэгт №1

Бодлогын баримт бичгийн төлөвлөлт

№	Бодлогын баримт бичиг	Дэвшүүлсэн зорилт	Арга хэмжээ	Санхүүжилт	
				Эх үүсвэр	Дүн /сая төгрөг/
Дунд хугацааны бодлогын баримт бичиг					
1	Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/	6	18	ОНТ, Хувийн хэвшил	240.2
2	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /2020-2025/	8	18	УТ, ОНТ, Хувийн хэвшил	78.6
Богино хугацааны бодлого					
3	Аймаг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө /2022/	7	17	УТ, ОНТ, Хувийн хэвшил	121.5
Аймгийн дэд хөтөлбөр					
4	Дундговь ноогооруульа хөтөлбөр	3	16	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр хувийн хэвшил, иргэн, ААН	282.5

Эх сурвалж: Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүд

Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2021-2022 онд 1 төсөл хөтөлбөрийг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан боловч тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулаагүй байна

Мөн ан амьтан, ургамал, ойн талаар авах арга хэмжээнүүд үндсэн чиглэл, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгаж төлөвлөөгүй байна.

Энэ нь Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой ажлыг хариуцсан байгууллага хоорондын уялдаа холбоо муу, урт хугацааны хөгжлийн

бодлого, стратеги төлөвлөгөөг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслээгүй, жил бүр хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаагүй, хэрэгжилтийн үр дүнг тооцоогүйтэй холбоотой байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 89 дүгээр тогтоолоор байгаль орчинд хамааралтай дараах хөтөлбөрүүдийг хүчингүй болгосон бөгөөд шинээр үүнтэй холбоотой эрх зүйн актууд боловсруулагдаагүй байна. Үүнд:

- ★ Төрөөс экологийн талаар баримтлах бодлого / УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоолоор батлагдаж байсан /
- ★ 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаар тогтоолоор "Ногоон хөгжлийн бодлого"
- ★ “Ус” үндэсний хөтөлбөр батлах тухай / УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоолоор батлагдаж байсан /
- ★ Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр батлах тухай / УИХ-ын 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдаж байсан/

Энэ нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар бодлогын баримт бичгийг боловсруулахад ямар эрх зүйн актыг үндэслэл болгон мөрдөх нь тодорхойгүй нөхцөл байдлыг бий болгож байна. Уг хөтөлбөрүүдийн хамрах хүрээний асуудлууд нь байгаль орчны асуудалтай ихээхэн хамааралтай бөгөөд аймагт “Дундговьо ногооруульа” хөтөлбөр 2021 оноос хэрэгжиж байна.



УИХ, Засгийн газрын тогтоолоор батлагдсан Үндэсний хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас батлан гаргасан хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс, газрууд заасан хугацаанд тайлагнасан байна.

Аудитад шаардлагатай 2021, 2022, 2023 оны бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээ, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг, менежментийн төлөвлөгөөний биелэлтийн баримт материалыг гаргаж ирүүлэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст албан тоотоор хүргүүлсэн. Аудитын хугацаанд дээрх баримт материалыг гаргаж ирүүлээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.15 дах заалтыг зөрчиж байна. Иймд аймгийн Засаг даргаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт болон харьяа төсөв захирагч, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, гаргаж ирүүлээгүй холбогдох буруутай албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

А.1.2 Аймгийн хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичгийг баталж, тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаж, үнэлсэн боловч бодит үр дүнг тооцон ажиллаагүй байна.

Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх эдийн засгийн урт хугацааны бодлого, стратегид хүрэхэд эн түрүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай дунд хугацааны зорилго, зорилт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, мөн Алсын хараа-2050 хөгжлийн бодлогын баримт бичиг, 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл,

аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичигт Ногоон хөгжлийн бодлогын талаар 6 зорилт, 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт байгалийн нөөцийг нөхөн сэргээлтийн талаар 160.0 сая, тусгай хамгаалалттай холбоотой 16.2 сая, нийт 176.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулахаар төлөвлөсөн боловч зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, эх үүсвэрийг бодитой тооцож төлөвлөөгүй байна. Үүнд:

- Нөхөн сэргээлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх;
- Булаг шанд, усыг түшиглэн хур тунадас, цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах тэмдэгжүүлэх хамгаалалтын бүс тогтоох ажлыг 110 цэгт зохион байгуулах;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг байна.

Энэ нь төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх, дараагийн урт болон богино хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэлтэй төлөвлөх боломжгүй болгох эрсдэлтэй байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна. Тухайлбал: Аймгийн хэмжээний байгалийн нөөцийг нөхөн сэргээх зардлын тооцоо, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх боломжтой хэмжээ, хандив тусламж санхүүжилтийн өөр эх үүсвэр бий эсэх зэргээр тодорхой судалгаа хийж төлөвлөх нь зүйтэй байна.

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Ногоон хөгжил” бүлэгт 2 зорилт, 6 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг жил бүр дүгнэсэн байна. Харин аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд зарим арга хэмжээг цар хүрээ багатай, хэрэгжүүлэх ажлын хүрэх үр дүн нь тодорхойгүй төлөвлөжээ. Жишээ нь: Усны бохирдол, хомсдолоос сэргийлж, шаардлага хангасан ундны эх үүсвэртэй холбоотой 4 арга хэмжээ, ногоон байгууламжтай холбоотой 2 арга хэмжээ, тусгай хамгаалалттай холбоотой 2 арга хэмжээ төлөвлөсөн хэдий ч хүрэх түвшин тодорхойгүй, ой, амьтан, ургамлын нөөц тогтоох ажил хийгдээгүй энэ чиглэлээр бодлогын баримт бичигт тодорхой тусган оруулж өгөөгүй байна.

А.1.3 Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдүүлсан менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн байна.

Дундговь аймгийн байгалийн ургамлын менежментийн төлөвлөгөө



Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 24-р тогтоолоор Дундговь аймгийн байгалийн ургамлын 2019-2024 онд хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөг баталж, байгалийн ургамлын тархалт, нөөцийг хамгаалах менежментийн төлөвлөгөө болон байгалийн ашигт ургамлын тархац, нөөц тогтоох нарийвчилсан судалгааны ажлыг гүйцэтгэх шаардлагатай төсвийг батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Засаг даргад даалгажээ.

Аймгийн хэмжээнд судалгаа явуулсан болон урьд жилүүдийн хийсэн судалгаа ургамлын цуглуулга, бичиглэлийг харьцуулан боловсруулж 39 овогт хамаарах 123 төрлийн

202 зүйл ургамал бүртгэсэн байна. Эдгээр бүртгэсэн зүйл ургамлын дотор **нэн ховор 6 зүйл, ховор 10 зүйл, Эндемик 3 зүйл, Субэндемик ургамал 13 зүйл, ашиглалтад өртөмтгий ашигт ургамал 27 зүйл ургамал менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байна.**

Дундговь аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө: Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн тогтоолоор Дундговь аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг батлан 2017-2022 он хүртэл хэрэгжээд байна. Уг төлөвлөгөөнд аймгийн нутагт агнуурын ач холбогдолтой аргаль хонь, янгир ямаа, цагаан зээр, хар сүүлт, монгол тарвага, саарал чоно, шар үнэг, хярс үнэг бүртгэсэн байна.



Сүүлийн жилүүдэд агнуурын зарим хөхтөн амьтад (аргаль хонь) шинээр нутагшиж, тоо толгой өсөж, тогтворжих хандлагатай байгаа нь сайшаалтай боловч нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд нүүрлэж буй байгаль цаг уур, хүний шууд болон дам хүчин зүйлийн улмаас бүс нутгийн хөхтөн амьтны хэвийн тогтвортой байршил алдагдах, тоо толгой нь цөөрөх, тархац нутгийн зарим хэсэгт ховордон байхгүй болох зэргээр хөхтөн амьтдын элдэв хэлбэрт нөлөөлөх үйл ажиллагаа өдрөөс өдөрт эрчимжиж байна.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь ан амьтдыг хамгаалах, сэргээн нутагшуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй, тогтвортой, зүй зохистой ашиглах талаар санаачилгатай ажиллаж монгол тарвага сэргээн нутагшуулах ажлыг мэргэжлийн байгууллагууд болон төрийн бус байгууллага, орон нутгийн иргэдийн оролцоотой хэрэгжүүлж байна.

Дундговь аймгийн хэмжээнд үндэсний болон олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд тал хээрийн, уулын туруутан болон монгол тарваганы агнуур зохион байгуулалтын судалгааг харилцан адилгүй цаг хугацаанд гүйцэтгэж байсан боловч 2017 оноос өмнө менежментийн төлөвлөгөө боловсруулан, батлагдаж байгаагүй байна.

Дундговь аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө нь 2017-2022 онуудад хэрэгжих бөгөөд энэхүү төлөвлөгөөнд бүс нутгийн экосистемийн хэв шинжид дасан зохицож амьдарч буй биологийн олон янз байдал, ялангуяа ховор болон агнуурын ач холбогдолтой хөхтөн амьтдын популяцийг хамгаалах ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр, орон нутгийн удирдлага нутгийн иргэдийн оролцоог зохистой хэлбэрээр тусгасан байна.



Дундговь аймгийн ойн менежментийн төлөвлөгөө: Шороон шуурганы давтагдал жилээс жилд нэмэгдэж 2016 оноос 2020 он гэхэд даруй 182-оор, 15 м/с-ээс дээш хүчтэй салхитай өдрийн тоо 3 дахин, нөөлөг салхитай өдрийн тоо 4 дахин өссөн байна.

Аймгийн нийт нутгийн 90 гаруй хувьд цөлжилт эрчимтэй явагдаж байгаа нь аймгийн “Ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030”-г боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх нэг гол хөшүүрэг болсон байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 60-р тогтоолоор аймгийн “ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүрийн 4-р улиралд багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнахыг аймгийн Засаг даргад даалгасан байна. Хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсээр тайлагнахаар байна. Ойн менежментийн мастер төлөвлөгөөний зорилгыг 6 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, ойн менежментийн мастер төлөвлөгөөг 2023-2030 онд дараах үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнд:

- Бэлтгэл ажил хангаж ажлыг эхлүүлэх 2022-2024
- Мод тарьж ургуулах, ойжуулах ажлыг зохион байгуулах 2025-2028
- Амьдралт, ургалт, өсөлтийг дэмжих, арчлах 2029-2030

Ойн менежментийн мастер төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. (Хүснэгт 2)

Хүснэгт №2.

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин /2030 он/
1	Мод үржүүлгийн газруудыг нэмэгдүүлж, говь цөлийн бүсийн мод, сөөгийг үр болон мөчрөөр үржүүлэх	Тоо хэмжээ	3	15
2	Байгалийн заган ойн сэргэн ургалтыг дэмжих, ойжуулалт хийх	га	-	1800
3	Төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	га	74	225
4	Ойн зурвас талбай байгуулах	га	417.4	45276

Дундговь аймгийн усны менежментийн төлөвлөгөө: Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 5 сарын 31-ны өдрийн А/233-р тушаалаар Умард Говийн -



Халхын дундад талын сав газрын менежментийн төлөвлөгөөг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 1 үе шат 2020- 2024, 2 үе шат 2025-2029, 3 үе шат 2030-2035 хэрэгжихээр төлөвлөсөн байна.

Тус төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой 8 арга хэмжээ тусгагдсанаас 2021 онд 3 арга хэмжээ төлөвлөснөөс 3 арга хэмжээ хэрэгжиж 90 хувьтай дүгнэгдсэн бол, 2022 онд 5 арга хэмжээ төлөвлөснөөс 5 арга хэмжээ хэрэгжиж 81.2 хувьтай дүгнэгдэж, 2023 онд 2 зорилтыг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөсөн байна.

Аудитын явцад дээрх арга хэмжээний гол гол заалтуудаас авч үзэхэд Мандалговь хотын ирээдүйн хөгжил (хот байгуулалт, дулааны станц, ноос угаах үйлдвэр байгуулах г.м)-ийн үе шатуудад хүн амын ундны усны шинэ эх үүсвэрийн хайгуул хийж, Олгойн говийн усны эх үүсвэрийг үйлдвэрлэлийн ус хангамжийн зориулалтаар шинэчлэхээр тусгасан байна. Мөн Дундговь аймгийн Цагаандэлгэр, Дэрэн, Адаацаг, Гурвансайхан, сумдын төвүүдийн хүн амын ундны усны эх үүсвэрийн нэмэлт хайгуул хийж шинэ эх үүсвэрийг иж бүрнээр байгуулах, аймгийн хүнс, хөнгөн үйлдвэрүүдийг ус хангамж ариутгах татуургад бүрэн холбож тоолууржуулах ажлууд хийгдэхээр тусгагдсан нь сайшаалтай байлаа.

А.2 Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, төлбөр түүнтэй холбогдох харилцааг тусгаж дүгнэсэн байна.

А.2.1 БОАЖ-ын сайд аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээнд байгалийн нөөцтэй холбоотой харилцааг тусгаж, дүгнэсэн байна.



Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, үндсэн чиглэлийн биелэлт, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг салбарын сайдтай байгуулсан гэрээний хүрээнд тайлагнасан байна. Чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэлийг зорилт бүрийн дагуу тайлагнаж дүгнэлтийг бүлгийн хүрээнд үнэлсэн байна.

Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх цөлжилт, газрын доройтол, элсний нүүдэл шороон шуурганы сөрөг нөлөөллийг багасгах, байгаль орчноо хамгаалах, нөхөн сэргээх, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Дундговьо ногооруулья” хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аудитаар аймгийн Засаг даргын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр болон байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой арга хэмжээнүүдийг аймгийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан эсэх талаар авч үзлээ.

Аймгийн Засаг даргын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээнд 2021 онд ногоон хөгжлийн бодлоготой холбоотой 9 зорилтын 50 арга хэмжээ, 2022 онд 8 зорилтын 60 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас 2021 онд байгалийн нөөцийн ашигласны төлбөр 5, байгаль орчныг хамгаалахтай холбоотой 3, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой 5 заалтыг төлөвлөсөн, 2022 онд 3 зорилтын 16 арга хэмжээг төлөвлөж баталжээ. Эдгээр заалтууд нь аймгийн бодлогын баримт бичгүүдэд туссан боловч хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэр нь бодитой бус, тодорхойгүй байлаа.

Аймгийн Засаг даргын салбарын сайдтай байгуулсан байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээгээр 2021 онд 97.3, 2022 онд 97.2 хувьтайгаар үнэлж дүгнэгдсэн байна. 2021 онд нийт 30 арга хэмжээ хэрэгжүүлснээс 19 нь үр дүнтэй, 5 нь тодорхой үр дүнд хүрсэн, 4 нь үр дүнгүй гэж үнэлэгдсэн бөгөөд 2 арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байсан байна. Аймгийн Засаг даргын салбарын сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал: (Хүснэгт 3)

Хүснэгт №3.

Бодлогын баримт бичгийн нэр	Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой асуудлууд	Хяналт шалгалт хийгдсэн эсэх, хэрэгжилтийн хувь	Хүрэх түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих боломжтой эсэх	Санхүүжилтийн эх үүсвэр, мөнгөн дүн	Бодлогын баримт бичгийн хоорондын уялдаа холбоо	Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой бодлого төлөвлөлт, Дундговьо ногооруулья хөтөлбөртэй уялдаж байгаа эсэх
БОАЖС-тай байгуулса	13	97.3	Хүрэх	Шалгуур тодо	13 заалтын 4 нь санхүүжилтийн	АЗДҮАХ-т 5 заалт тусгагдсан боловч, 5 жилийн ЭЗНХҮЧ-д	5

н 2021 гэрээ				эх үүсвэр тодорхойгүй	3 заалт тусгагдсан байна.	
БОАЖС- тай байгуулса н 2022 гэрээ	16	97.2		16 заалтын 6 нь санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй	АЗДҮАХ-т 5 заалт тусгагдсан боловч, 5 жилийн ЭЗНХҮЧ-д 3 заалт тусгагдсан байна.	4

А.2.2 Аймгийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж дүгнэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас байгалийн нөхөн сэргээлттэй холбоотой 3 заалт, гадаргын усан хангамжийг нэмэгдүүлэхтэй холбоотой 3 заалт, тусгай хамгаалалтын газар нутагтай холбоотой 3 заалт, зэрлэг амьтан нөөцийг хомсдолыг бууруулахтай холбоотой 2 заалт, ойн зурвас байгуулахтай холбоотой 2 заалтыг төлөвлөсөн байна. Мөн хог ангилан ялгах, дахин боловсруулах, булшлах болон уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой 5 заалтыг тус тус тусгасан байна.

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой 18 заалт баталснаас байгалийн нөхөн сэргээлттэй холбоотой 3, ногоон байгууламжтай холбоотой 2 заалт, тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой 3 заалт төлөвлөсөн байна.

“Дундговьго ногооруулъя” хөтөлбөрийн хүрээнд нийт 3 зорилт, 17 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой 3 заалт, заган ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулахтай холбоотой 1 заалт, нөхөн сэргээлттэй холбоотой 3, ногоон байгууламжтай холбоотой 3 заалт төлөвлөсөн байна.

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний 8 заалтаас “Дундговь ногооруулъя” хөтөлбөрт 5 заалт тусгаж, 3 заалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй бол аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан 6 заалтаас 5 заалтыг тусгаж, 1 заалт тусгагдаагүй байна.

Энэ нь байгалийн нөөцийг хамгаалах, ашиглалт, нөхөн сэргээлтийн холбоотой ажлыг хариуцсан байгууллага хоорондын уялдаа холбоо муу, урт хугацааны болон жил бүр хийгдэх ажлын төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэн нарийвчлан гаргаагүй, арга хэмжээнд шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлээгүйтэй холбоотой байна.

Иймд байгалийн нөөцийг хамгаалах, ашиглалт, нөхөн сэргээлтийн холбоотой үндэсний болон салбарын бодлого, хөтөлбөрт үндэслэн аймгийн бодлогын баримт бичиг, үйл ажиллагааг урт хугацаагаар төлөвлөж, жил бүрийн хийгдэх ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрээр байгаль нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөөнд зардлыг нарийвчлан тусгаж байх шаардлагатай байна.




БҮЛЭГ 2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль журмын дагуу хэрэгжээгүй байна.

Б.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөхгүй байна.

Б.1.1 Байгалийн нөөцийг тогтоох ажил хангалтгүй, нөөц ашиглах төрлийн дээд хэмжээг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

Дундговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөөцийг тогтоосон байдлыг авч үзвэл усны болон ан амьтны нөөц тогтоох ажил хийгдэж байсан бол ургамлын нөөц тогтоох ажил ерөнхий судалгааны түвшинд байна.

Усны нөөц тогтоолт: Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Умард гүвээт- Халхын дундад талын сав газрын захиргааны гаргасан 2020 оны мэдээллээр Дундговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын доорх усны хайгуул судалгаа хийгдэж, нөөцийг тогтоосон 21 усны нөөц орд байна. Усны нөөц бүхий ордуудаас 2 ордын нөөцийг 2014 болон 2017 онд баталгаажуулсан, 15 ордын нөөцийг 1986-1999 оны хооронд тогтоосон ч ашиглалтын тооцоолол, баталгаажуулалт хийгдээгүй байна. Харин 2009-2013 оны хооронд сумын төвийн бус байршилтай 4 ордын нөөцийг тогтоож, ашиглалтын хугацааг 7-12 жилээр баталсан ч тус ордуудыг ашиглаагүй байна. (Хүснэгт 4)



Нөөц тогтоогдсон газрын доорх цэнгэг усны ордууд (Умард ГХХДТСГЗ 2020 оны усны бүртгэл тооллого)

Хүснэгт №4

№	Сумын нэр	Ордын нэр	Байршил	Нөөц л/сек	Баталсан он	Ашиглалтын хугацаа
1	Сайнцагаан	Тэвшийн говь	Төвийн бус	22.5	1986	27
2	Сайнцагаан	Сумангийн говь	Төвийн бус	-	1986	27
3	Сайнцагаан	Олгойн говь-1	Төвийн бус	19.0	1986	27

				11.8	2014	25
4	Сайнцагаан	Олгойн говь-2	Төвийн бус	5.0	1988	27
5	Сайнцагаан	Мандал сүүж	Төвийн бус	-	1998	10
6	Сайнцагаан	Хүйтэн булаг-1	Төвийн бус	9.0	1999	15
7	Луус	Сумын төв	Сумын төв	6.0	1990	27
8	Хулд	Сумын төв	Сумын төв	5.4	1990	-
9	Дэлгэрхангай	Сумын төв	Сумын төв	4.5	1991	27
10	Эрдэнэдалай	Сумын төв	Сумын төв	4.5	1996	27
11	Өлзийт	Сумын төв	Сумын төв			
12	Говь-Угтаал	Сумын төв	Сумын төв	2.0	1995	25
13	Дэлгэрцогт	Сумын төв	Сумын төв	6.0	1991	27
14	Өндөршил	Сумын төв	Сумын төв	4.0	1991	27
15	Сайхан-Овоо	Сумын төв	Сумын төв	19.3	2017	25
16	Гурвансайхан	Мандал-Уул	Төвийн бус	5.0	1990	27
17	Гурвансайхан	Улаан толгой	Төвийн бус	29.5	1990	27
18	Цагаандэлгэр	Их талын хотгор	Төвийн бус	50.0	2011	10
19	Баянжаргалан	Зараагийн ар хөндий	Төвийн бус	-	2013	10
20	Өлзийт	Хайрхан	Төвийн бус	1.1	2009	12
21	Эрдэнэдалай	Оюут-Овоо	Төвийн бус	21.3	2010	7

Дээрх усны хайгуул хийж нөөц тогтоосон 21 ордоос Сайнцагаан сумын нутагт 6, Луус, Хулд, Өлзийт, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Өндөршил Сайхан-Овоо сумдын сумын төвд тус бүр 1 буюу 9 орд, харин Баянжаргалан, Цагаандэлгэр, Гурвансайхан, Өлзийт, Эрдэнэдалай сумын төвийн бус байршилд нийт 6 орд оршиж байна.

Ан амьтны нөөц тогтоолт: Агнуур зохион байгуулалтын судалгааг 5 жил тутамд хийдэг бөгөөд 2023 онд шинээр судалгаа хийхээр төлөвлөөд гүйцэтгэлийн шатанд байна. Ан



агнуурын 2017 оны судалгаагаар аймгийн нутаг дэвсгэрт цагаан зээр, хар сүүлт, аргаль хонь, янгир ямаа, тарвага болон бусад хөхтөн амьтдын нөөцийг судалж тогтоосон байна. Судалгааны дүнгээр угалз агнуурын бүс байгуулах боломжтой нутаг Өлзийт, Баянжаргалан, Дэлгэрцогт, Адаацаг сумдад, тэх агнуурын бүс байгуулах боломжтой газар нь Өлзийт, Сайхан-Овоо сум, тарвага агнуурын бүс байгуулах боломжтой газар Баянжаргалан сумын

нутагт байхаар үнэлгээ хийгдэж, жил бүр ан агнуурын төрөл дээд хэмжээний саналаа Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж, батлагдаж ирсэн хяналтын тоогоор орлогын төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлдэг байна.

Их газрын чулууны байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа нь байгуулагдсан цагаас эхлэн хариуцсан нутаг дэвсгэрийн туруутан амьтдын тооллогыг жилдээ 2 удаа зохион байгуулж байгаа бөгөөд 2022 оны тооллогын дүнгээр өмнөх оны тооллого судалгаатай харьцуулан дүгнэхэд аргаль, янгирын тоо төлөөр тогтмол өссөн үр дүнтэй байна. Мөн сүргийн бүтцийн ажиглалт хийхэд аргаль, янгирын 60-70 хувийг эм бодгалийн тоо давамгайлж байгаа нь цаашид уулын туруутан амьтан илүү өсөх хандлагатай байна. Тус нутаг дэвсгэр нь байгалийн цогцолбор газрын ангилалд багтаж, хамгаалалтын захиргаатай болсон тул хуулиар ан агнуурын үйл ажиллагаа явагддаггүй байна.

Ургамлын нөөц тогтоолт: Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2018 онд аймгийн нутаг дэвсгэр дээр ургадаг ургамлын ерөнхий судалгааг хийж тодорхойлсон бөгөөд Дундговь аймагт 39 овогт хамаарах 123 төрлийн 202 зүйлийн ургамал хээрийн судалгаагаар бүртгэгдсэн мөн 20 овгийн 28 төрлийн 37 зүйл ургамлын тархац, 9 зүйл ургамлын нөөцийн судалгаа хийгдсэн. Харин нөөцийг тогтоосон нарийвчилсан судалгаа хийгдээгүй тул ургамлын нөөцийг ашиглах талаарх саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлдэггүй байна. 2019 онд судалгааны ажлыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж байгалийн ургамлын менежментийн төлөвлөгөөг батлуулсан байна.

Ойн нөөц тогтоолт: Дундговь аймгийн ойн нөөцийн хувьд Өлзийт сумын нутаг дэвсгэрийн 32,759 га бүхий тусгай хамгаалалттай газрын 16,793 га талбайд Заган ой байна. Тус заган ой нь аймгийн нутаг дэвсгэрийн 0.22 хувийг эзэлж байна. Заган ойг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаггүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” журмын дагуу аймгийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад хүргүүлэхээр зохицуулалттай хэдий ч хүргүүлдэггүй байна. Харин аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас албан бичгээр жил бүрийн 10 дугаар сард Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт хүргүүлсээр ирсэн байна. Тус саналд 2021 онд 12 угалз, 9 тэх, 20 цагаан зээр, 2022 онд 12 угалз, 12 тэх, 25 цагаан зээр, 2023 онд 12 угалз, 13 тэх, 27 цагаан зээр агнах, ахуйн зориулалтаар 50 агнуурын шувуу, 130 цагаан зээр агнуулах саналыг хүргүүлсэн байна. (Хүснэгт 5)

Хүснэгт №5

	Төрөл	БОАЖЯ-д хүргүүлсэн санал			БОАЖЯ-наас батлагдсан тоо		2021-2022 оны санал, батлагдсан ангийн тоотой харьцуулахад /Хувь/
		2021	2022	2023	2021	2022	
1	Угалз /Агнуур/	12	12	12	6	3	37.5
2	Тэх /Агнуур/	9	12	13	2	-	9.5

3	Цагаан зээр /Агнуур/	20	25	27	20	25	100
4	Цагаан зээр /Ахуйн зориулалт/	200	100	100	200	100	100
5	Шувуу /Ахуйн зориулалт/	50	50	50	50	50	100

Байгалийн нөөцийг тогтоох ажил ургамлын хувьд хийгдээгүй, ус, ан амьтны нөөцийн төрөл дээр хийгдэж ирсэн бөгөөд ашиглах төрөл, дээд хэмжээг судалгаанд үндэслэн төлөвлөж саналаа Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлдэг байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас агнуурын болон ахуйн зориулалтаар агнах цагаан зээр, шувууны тоог аймгийн саналаар баталдаг ч 2021-2022 онд угалз -62.5 хувь, тэх -90.5 хувиар бууруулж агнах тоог баталсан байна.

Байгалийн ан амьтан, усны нөөцийг шинэчлэн тогтоох, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх, аймгийн нутаг дэвсгэр дэх ургамлын нөөцийг тодорхойлох нөөцийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Б.1.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрдүүлэх харилцаа журмын дагуу бүрэн хэрэгжихгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээ болон түүнээс дээш хэмжээгээр орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” -аар зохицуулагдаж байна.

Тус журмын 2.3, 2.4, 2.6, 2.7 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаж байгаа бол 2.2, 2.5 дахь заалтын хэрэгжилт хангагдахгүй байна. Тухайлбал: 2.2-д заасан аймгийн Засаг даргаас нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор хүргүүлэхээр заасан боловч Байгаль орчин, аялал жуулчлалын газраас жил бүрийн 10 дугаар сард хүргүүлдэг байна.

Мөн журмын 2.5-д заасан сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг журмын хавсралт БНАТ-1 маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэх зохицуулалттай ч хэрэгжүүлдэггүй, байгаль орчин аялал жуулчлалын газраас сумдтай утсаар холбогдож, саналыг нь авдаг байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэх 2.2, 2.5 дахь заалтыг хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

Б.1.3 Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгож байна.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ус ашиглах дүгнэлтийг гаргадаг бол ан агнуурын бүс тогтоох, агнуур зохион байгуулах зөвшөөрлийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгодог байна. Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Засгийн газрын 2011 оны 302, 2013 оны 326, 327 дугаар тогтоолд үндэслэн ус ашиглагч байгууллагын хүсэлтийг судалж дүгнэлт гаргасан байна. Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2021-2022 онд нийт 68 дүгнэлт гаргасан бол их хэмжээний ус ашиглагч байгууллагуудын дүгнэлтийг Усны сав газрын захиргаанаас хууль, журмын дагуу гаргаж шийдвэрлэж байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2015 оноос 6 агнуурын бүсэд, 6 нөхөрлөл байгуулан менежментийн төлөвлөгөөний дагуу агнуурын ажил, хамгааллын ажил, нутгийн иргэдэд экологийн боловсролыг дээшлүүлэх, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих ажлыг зохион байгуулж ирсэн байна. Ангийн квотыг Байгаль орчин, аялал жуулчлалын газраас менежментийн төлөвлөгөө болон сум, ангийн менежмент хариуцагчийн саналыг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж байна. Саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас судлан квотыг сайдын тушаалаар баталдаг. Агнуурын менежмент хариуцагч 2023 оноос ажиллахгүй бөгөөд дуудлага худалдаагаар зохион байгуулахаар болсон ч одоогоор дуудлага худалдааг хэрхэн зохион байгуулах талаар чиглэл өгөөгүй байна.

Б.1.4 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төвлөөгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас батлагдсан тоо хэмжээнд үндэслэж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар төлөвлөгөөг баталдаг. Ус, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг аймгийн Татварын хэлтэс, газрын төлбөрийн орлогын ногдуулалтыг Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар хийж, орлого төвлөрүүлэх ажлыг аймгийн Татварын хэлтэс болон сумдын татварын байцаагч нар хариуцан ажилладаг байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон аймгийн Татварын хэлтсээс 2020-2022 он болон 2023 оны 05 сарын 31-ний өдрийн байдлаар гүйцэтгэлийг гаргуулж, зөрүүтэй тоон мэдээллийн зөрүүг арилгах ажлыг зохион байгуулж нэгтгэхэд дараах байдалтай байна. (Хүснэгт 6)

Хүснэгт №6

	2020 он		2021 он		2022 он		2023 оны санал	
Төрөл	төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц	Төл	гүйц
Ан амьтан	30.4	182.8	167.3	644.2	200.0	666.7	280.0	-
Усны нөөц	25.0	100.7	60.0	252.4	100.0	403.1	150.0	145.6
Газрын төлбөр	240.0	351.7	285.0	402.2	362.0	537.7	517.3	470.5
Нийт	295.4	635.3	512.3	1,298.8	662.0	1,607.6	947.5	616.2

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын СТСХ, Татварын хэлтсийн мэдээнээс

Аймагт жил бүр ус, газар, ан амьтны нөөц болон газрын төлбөрийн орлого төвлөрүүлэхээр батлагдаж тус орлогыг төвлөрүүлдэг. Усны төлбөрийн орлого 2020-2022 онд төлөвлөгөөгөөр 4.0-4.2 дахин давж биелсэн бол ногдуулалттай харьцуулахад жил бүр 83.2-115.7 хувиар биелсэн байна. Төлөвлөгөө давж биелсэн шалтгаан нь Гурвансайхан

сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй Эрдэнэс силвер ресурс ХХК болон бусад уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа тогтмолжсонтой холбоотой байна.(Хүснэгт 7)

Хүснэгт № 7

	Төлөвлөгөө (сая.төгрөг)	Ногдуулалт (Сая.төгрөг)	Гүйцэтгэл (Сая.төгрөг)	Ногдуулалтын биелэлт (хувь)	Төлөвлөгөөний биелэлт (хувь)
2020	25.0	121.0	100.7	83.2	402.8
2021	60.0	218.2	252.4	115.7	420.7
2022	100.0	404.3	403.1	99.7	403.1
2023.05 сар	150.0	-	145.6	-	97.1

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөгөөгөөр 3.3-6.0 дахин давж биелсэн бол ногдуулалттай харьцуулахад 2020-2021 онд 2.5-8.7 дахин давж биелсэн бол 2022 онд 4.8 хувиар тасарсан байна. Төлөвлөгөө давж биелэх болсон шалтгаан нь төлөвлөгөөгүйгээр сумдаас шонхор шувууг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны зөвшөөрлөөр бариулсны орлого орж ирсэнтэй холбоотой байна. (Хүснэгт 8)

Хүснэгт №8

	Төлөвлөгөө (сая.төгрөг)	Ногдуулалт (сая.төгрөг)	Гүйцэтгэл (сая.төгрөг)	Ногдуулалтын биелэлт (хувь)	Төлөвлөгөөний биелэлт (хувь)
2020	30.4	21.3	182.9	870.9	601.6
2021	167.3	253.2	644.2	254.4	385.1
2022	200.0	700.3	666.7	95.2	333.4
2023.05сар	280.0	-	-	-	-

Аймгийн хэмжээнд иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулсан газрын төлбөрийг Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу ногдуулж, хуулийн хугацаанд нь газрын төлбөр, татварын системээр дамжуулан төлбөрийн нэхэмжлэлийг үүсгэдэг. Газрын төлбөр төлөлтийн мэдээ татварын системээс 30 минутад газрын төлбөр, татварын систем рүү илгээдэг гэх боловч төлөлтийн мэдээ татварын системээс ирэхгүй байгаагийн улмаас газрын төлбөрөө төлсөн зарим нэгж талбарын газрын төлбөр төлөөгүй төлөвтэй байдаг нь тайлан мэдээ гаргахад, хяналт тавихад хүндрэл гардаг байна.

Газрын төлбөрийн орлого жил бүр төлөвлөгөөгөөр биелдэг ч газрын төлбөрийн ногдуулалттай харьцуулахад жил бүр 10.0-16.2 хувиар тасардаг байна. 2023 оны 05 сарын 31-ний өдрийн байдлаар батлагдсан орлогын төлөвлөгөөний биелэлт 90.9 хувьтай, ногдуулалттай харьцуулахад 30.5 хувийн биелэлттэй байгаа нь төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөж батлуулсантай холбоотой байна. (Хүснэгт 9)

Хүснэгт № 9

	Төлөвлөгөө (сая.төгрөг)	Ногдуулалт (сая.төгрөг)	Гүйцэтгэл (сая.төгрөг)	Ногдуулалтын биелэлт (хувь)	Төлөвлөгөөний биелэлт (хувь)
2020	240.0	398.3	351.7	88.3	146.5
2021	285.0	480.0	402.1	83.8	141.1
2022	362.0	597.6	537.7	90.0	148.5
2023	517.5	1,541.1	470.5	30.5	90.9

Газрын төлбөрт татварын системийг нэвтрүүлж, цахимаар төлбөрийн ногдуулалт үүсгэн нэхэмжлэлийн дагуу газар эзэмшигч, ашиглагч газрын төлбөр төлдөг болсонтой холбогдуулан мал бүхий иргэдэд газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэх боломжгүй болсон. Учир нь газрын төлбөр нь тухайн нэгж талбартай /газартай/ холбогдсоны дараа нэхэмжлэл үүсдэг байна. Мал бүхий иргэний хөрөнгийн бүртгэл татварын системд үүсэх боломжгүй зэрэг шалтгааны улмаас системд ногдуулалт, нэхэмжлэл үүсэх боломжгүй тул бэлчээрийн татварт ногдуулалт хийгдэхгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө судалгаа шинжилгээ хийж, усны төлбөрийн болон газрын төлбөрийн орлогыг хуулиарх ногдуулалт, өмнөх оны гүйцэтгэл зэрэгт үндэслэн бодитой төлөвлөж орлогыг хураах бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Б.2 Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтыг хуулийн дагуу зарцуулаагүй байна.

Б.2.1 Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын батлагдсан дүнгээр төлөвлөсөн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд төсвийг зарцуулдаг ч “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” -д заасан Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөж хуваарилаагүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т ан амьтны нөөц ашигласны төлбөрийн нийт орлогоос 50-иас доошгүй хувиар тооцож байгаль орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх зардлыг төлөвлөхөөр тусгасан байдаг. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх зардлыг ан амьтны нөөц ашигласны төлбөрийн нийт орлогоос төлөвлөөгүй аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын батлагдсан тухайн орлогын төлөвлөгөөнөөс хуульд заасан хэмжээгээр төлөвлөсөн байна.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрт 2020 онд 192.8 сая, 2021 онд 644.2 сая, 2022 онд 666.7 сая төгрөгийн орлого тус тус оржээ. Энэ төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төлөвлөсөн хөрөнгө дараах байдалтай байна. (Хүснэгт 10)

Хүснэгт №10

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хуулиар батлах /50%/	Батлагдсан	Сая .төг
					Зөрүү
2021	167.3	644.2	322.1	62.8	259.3
2022	200.0	666.7	333.3	120.4	212.9
Нийт дүн	367.3	1,119.7	559.8	183.2	472.2

Хүснэгтээс үзвэл 2021 онд батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуулийн хувиар тооцож, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн нь ан амьтныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих зардалд 472.2 сая төгрөгийг зарцуулах боломжийг алдсан байна.

Аймгийн хэмжээнд ан амьтны нөөц ашиглалтыг төлөвлөхдөө аргаль, янгир, цагаан зээрийн ангаас орох орлогоор тооцдог. Харин шонхор шувуу бариулах үйл ажиллагаа нь уг

шувууны байршил нь хоол тэжээлээсээ үүдэн өөрчлөгддөг хөдөлгөөнт ан учраас төлөвлөх боломжгүй байдаг байна.

Шонхор шувуунаас орох орлого нь Засгийн газрын 2006 оны 171 дүгээр тогтоолд заасан хэмжээгээр бүрэн төлөгддөг болсонтой холбоотойгоор орон нутагт орох ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл ихээр нэмэгдсэн байна. Эдгээр орлогыг төлөвлөөгүй байдаг тул төлөвлөгөөнөөс давсан орлогоор тооцож, үүнээс байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал огт зарцуулдаггүй байна.

Газрын төлбөрийн орлогоос 15-аас доошгүй хувиар тооцож байгаль орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх зардлыг төлөвлөхөөр Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан байна. Газрын төлбөрийн орлого 2020 онд 339.6 сая, 2021 онд 402.2 сая, 2022 онд 537.7 сая төгрөгийн орлого тус тус оржээ. Энэ төлбөрийн орлого болон түүнээс байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төлөвлөсөн хөрөнгө дараах байдалтай байна. (Хүснэгт 11).

Хүснэгт №11

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хуулиар батлах	Батлагдсан	сая .төг
					Зөрүү
2021	285.0	402.2	60.3	31.3	29.0
2022	362.0	537.7	80.7	54.3	26.4
Нийт дүн	647.0	939.9	141.0	85.6	55.4

Газрын төлбөрөөс орлогын 2021-2022 оны төлөвлөгөөний 15.0 хувиар тооцож байгаль орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх зардлыг баталснаас 2021-2022 онд газрыг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих зардал 55.4 сая төгрөгийг зарцуулах боломжийг алдсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн байгалийн дурсгалт болон нөөц газар, тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөг батлуулж, тус төлөвлөгөөтэй уялдуулж, ач холбогдлоор нь эрэмбэлж, жил бүр хийгдэх ажлыг санхүүжилтийн эх үүсвэрийн хамт тодорхойлж, хууль, журамд заасны дагуу төсөвт тусгуулан журамд заасан зориулалтаар зарцуулж, тайлагнах шаардлагатай байна.

Ургамлын нөөц тогтоогдоогүй мөн ойн нөөц бага буюу говийн тусгай хамгаалалттай бүсийн Заган ойгоос өөр нөөцгүй тул нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөөгүй байна.

Байгалийн ургамлын менежментийн төлөвлөгөөний дагуу байгалийн ургамлын нарийвчилсан судалгаа тооллогыг гүйцэтгэж, ховор, нэн ховор ургамлын нөөцийг тогтоох, хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д зааснаар ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос 35.0 хувиар тооцож байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд төлөвлөх ёстой. Тус аймгийн хувьд ус, рашааны нөөц ашигласны

төлбөрийн орлогын төлөвлөгөө болон гүйцэтгэл, уг орлогоос зардал төлөвлөсөн байдлыг хүснэгтээр харуулбал: (Хүснэгт 12)

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хуулиар батлах	Батлагдсан	Хүснэгт №12 сая .төг
					Зөрүү
2021	60.0	252.4	88.3	21.0	67.3
2022	100.0	403.1	141.1	35.0	106.1
Нийт дүн	160.0	655.5	229.4	56.0	173.4

Ус, рашаан ашигласны төлбөрөөс байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд заасан хувиар тооцож зардал төлөвлөж 2021-2022 онд төлбөрийн орлогын төлөвлөгөөний 35.0 хувиар тооцож зардлыг баталсан бол давсан орлогоос зардлыг батлаагүйгээс 2021-2022 онд усан орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавихад 173.4 сая төгрөгийг зарцуулах боломжийг алдсан байна.

Иймд байгалийн нөөц ашигласны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг төлөвлөхдөө менежментийн төлөвлөгөөний дагуу ач холбогдлоор нь эрэмбэлж, жил бүр хийгдэх ажлыг санхүүжилтийн эх үүсвэрийн хамт тодорхойлж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасны дагуу нийт орлогоос хувь хэмжээгээр тооцон баталж, зарцуулж, тайлагнах шаардлагатай.

Б.2.2 Төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд төсвийг зориулалтын дагуу зарцуулах ажил хангалтгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос зохих хэсгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг 2014-2021 онуудад Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоол, 2022 оноос эхлэн 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан журмаар зохицуулж ирсэн байна.

Ан амьтны төлбөрийн орлогоос 2021-2022 онд батлагдсан төсөвт багтаан сумд нутаг дэвсгэр дэх ан амьтан нутагладаг газруудад биотехникийн арга хэмжээ авах, хяналт тавих ажилд шаардагдах техник хэрэгсэл авах, шонхор шувууны үүр, суулт байгуулах зэрэг ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудад зардлыг зарцуулсан байна.

Дэрэн, Эрдэнэдалай, Өндөршил, Цагаандэлгэр, Сайнцагаан, Адаацаг сумд 2022 он болон 2023 оны 05 сарын 31-ний байдлаар ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил болох сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хогийн цэг шууж булшлахад зэрэг арга хэмжээнд 94.4 сая төгрөгийг ангийн орлогоос зориулалт бусаар зарцуулсан байна. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос хотод иргэд, албан хаагчдыг туршлага судлах, сургалтад хамруулах зориулалтаар 11 сум Байгаль хамгаалах сангаасаа нийт 92.0 сая төгрөгийг 2023 оны 04 сарын 06-11 -ний өдрүүдэд "Эх дэлхийгээ аваръя, жиргээ холбоо ТББ"-д шилжүүлсэн бөгөөд тус арга хэмжээ зохион байгуулагдаагүй цуцлагдсан байна. Арга хэмжээнд зориулж шилжүүлсэн зардлыг буцааж шилжүүлээгүй удсан, буцаан олгох талаар хариу мэдээлэлгүй байх тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. (Хүснэгт 13).

Хүснэгт №13

Он	Орлогын гүйцэтгэл	Батлагдсан зардал	Зардлын гүйцэтгэл	Зориулалт бус зарцуулсан	Тайлбар
2021	454.4	83.6	62.8	-	-
2022	666.7	100.0	120.4	56.0	Ногоон байгууламж, мод усалгаа, хогийн цэг шуух, булшлах
2023	-	140.0	158.3	117.9	5 сарын 31-ний өдрийн байдлаар хог хаягдал цэвэрлэх, нохой устгал /Ордос хот руу/

Шинээр боловсруулж буй ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлахад 2023-2027 онд ан амьтныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний саналыг нарийвчлан тусгах, менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг зориулалтаар дагуу зарцуулах шаардлагатай байна.

Усны төлбөрийн орлогоос 2021-2022 онд батлагдсан төсвөөр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь усан орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд УГГХДТСГЗ-наас батлуулсан усны нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд зардлыг зарцуулах ёстой боловч 2021–2022 онд зориулалт бусаар буюу усны нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил болох сумдын төвүүдийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд 30.0 сая төгрөгийг зарцуулсан байна. 2023 оноос усны төлбөрийн орлогын зарцуулах эрх аймгийн Засаг даргад шилжсэн байна.

Хүснэгт №14

Он	Орлогын гүйцэтгэл	Батлагдсан зардал	Зардлын гүйцэтгэл	Зориулалт бус зарцуулсан	Тайлбар
2021	251.1	30.0	21.0	7.6 +05	Ногоон байгууламж, мод усалгаа аялал жуулчлал
2022	402.9	35.0	35.1	22.4	Ногоон байгууламж, мод усалгаа
2023	145.6	52.5	-	-	

Газрын төлбөрийн орлогоос 2021-2022 онд батлагдсан төсвөөр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь газрын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаагаас бусад төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын арга хэмжээнд зардлыг зарцуулах ёстой боловч 2021 –2022 онд зориулалт бусаар буюу аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны зардал болох ИТМ аялал жуулчлалын үзэсгэлэн, нүүдлийн соёлын язгуур урлаг, өв соёлын арга хэмжээ, аялал жуулчлалын сургалт зөвлөгөөн, цахим аялал жуулчлал хөгжүүлэх болон Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зэрэг арга хэмжээнд 14.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Газрын төлбөрийн орлогын зарцуулах эрх 2023 оноос сумдын Засаг дарга нарт шилжсэн байна.

Хүснэгт №15

Он	Орлогын гүйцэтгэл	Батлагдсан зардал	Зардлын гүйцэтгэл	Зориулалт бус зарцуулсан	Тайлбар
2021	389.5	31.3	31.3	5.8	Аялал жуулчлалын эвент арга хэмжээ
2022	533.6	54.3	54.3	8.6	Аялал жуулчлалын эвент, үзэсгэлэн, сургалт зөвлөгөөн, цахим хөгжүүлэлт, БОАЖГ-ын албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт зарцуулсан
2023	470.5	77.6	-	-	

Аймгийн Засаг дарга нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулахгүй байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төсвийг Аймгийн ИТХ-аас жил бүрийн “Аймгийн төсөв батлах тухай” тогтоолоор баталдаг бол хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт, тэдгээрт зарцуулах хөрөнгийн хуваарийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталдаггүй байна. Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д: “*Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих*”, 16.2-т: “*Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах*”, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т: “*Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, сум, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална*” заасныг тус тус зөрчжээ.

Тухайн онуудад хэрэгжүүлэхээр баталсан арга хэмжээний төсвөөс 2021 онд 12.2 хувь, 2022 онд 49.9 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “*Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно*”, Засгийн газрын 2014 оны 43, 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” журмуудын “Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт” хэсгийн 3.1¹, 3.2², 3.3³ дах заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.

² Энэ журмын 3.1-д зааснаас бусад төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг харгалзахгүйгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.

³ Энэ журмын 3.1-д заасан нөхцөл, хязгаарыг хангаагүй тохиолдолд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор орон нутгийн төсвийн суурь зарлагыг санхүүжүүлэхгүй.

Аймгийн хэмжээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн жилийн нийт орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зардал батлахдаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1.1-д заасан хувь, хэмжээг мөрдөх шаардлагатай.

БҮЛЭГ 3. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавиагүй, мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллаагүй байна.

В.1 Хуулийн хэрэгжилтэд хяналт тавиагүй, мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллаагүй байна.

В.1.1 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн хөгжүүлэлтийг хийж сайжруулах шаардлагатай, байна.

Мэдээллийн сан бүрдүүлэх, ил тод байдлыг хангах зорилгоор 2022 оны 07 дугаар сараас <https://eic.mn/finance/> цахим хуудсыг нээн ажиллуулж эхэлсэн байна. Энэ цахим хуудсанд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны байцаагч нар батлагдсан маягтын дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, зарцуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг цаглабарын дагуу цахимаар байршуулах болсон нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35.1.17-д заасан Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн олон нийтэд нээлттэй, ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Харин цахим мэдээллийн сан дахь мэдээлэл нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого нэр төрлөөр харагдахгүй, мэдээний нэгтгэл гардаггүй сул талтай байна. Энэ нь хэрэглэгч орлогыг нэр төрлөөр, ил тодоор мэдээлэл авах боломжоор бүрэн хангагдахгүй байна. Цаашид цахим хуудасны хөгжүүлэлтийг хийж, шинэчлэх шаардлагатай байна.

В.1.2 Засаг даргын харьяа байгууллагуудыг мэргэжлийн арга зүй удирдлагаар хангаж ажиллахгүй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн байгаль орчин, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн 2022 оноос 3 удаа солигдсон, байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавихтай холбоотой мэдээлэл, судалгаа байхгүй байна. Тус ажил хариуцсан мэргэжилтэн албан тушаалын тодорхойлолт заасан зорилтын хүрээнд Засаг даргын харьяа байгууллагуудыг мэргэжлийн арга зүй удирдлагаар хангах ажил дутагдалтай байна. Энэ нь аудитад шаардлагатай мэдээлэл, судалгааг аудитын хугацаанд бүрэн гаргаж өгөхгүй хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгосон. Цаашид тухайн ажил хариуцсан мэргэжилтнийг ажлын байран дах сургалтад хамруулан мэдлэг ур чадварыг сайжруулж тогтвор суурьшилтай ажиллуулж, шаардлагатай байна.

В.2.2 Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хэрэгжилтэд хяналт хийгдээгүй байна.

Аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллагаас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна. Харин Сайнцагаан сумын ИТХ-ын байгаль орчин, аялал жуулчлал, хөдөөгийн хөгжлийн хороо, төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооноос Байгаль хамгаалах сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт үр дүнг тооцон ажилласан байна.

Цаашид Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой ажлыг хариуцсан байгууллага хоорондын уялдаа холбоо муу, урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслээгүй, жил бүр хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаагүй, хэрэгжилтийн үр дүнг тооцоогүй байна.
2. Мал бүхий иргэний хөрөнгийн бүртгэл татварын системд үүсэх боломжгүй шалтгааны улмаас системд ногдуулалт, нэхэмжлэл үүсэх боломжгүй бэлчээрийн татварт ногдуулалт хийхгүй байна.
3. “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” -д заасан Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөж хуваарилаагүй байна.
4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлогоос хуульд заасан хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх зардлыг батлаагүйгээс 701.0 сая төгрөгийг зарцуулах боломжийг алдсан байна.
5. Дэрэн, Эрдэнэдалай, Өндөршил, Цагаандэлгэр, Сайнцагаан, Адаацаг сумд ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил болох сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хогийн цэг шууж булшлахад зэрэг арга хэмжээнд 94.8 сая төгрөгийг ангийн орлогоос зориулалт бусаар зарцуулсан байна.
6. Аймгийн Засаг дарга нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулаагүй байна.
7. Аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллагаас байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн ИТХ-д:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцон, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулан биелэлтэд хяналт тавьж ажиллах;
2. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлах.

Аймгийн Засаг даргад:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу хийсэн ногдуулалт, өмнөх оны гүйцэтгэл зэрэгт үндэслэн орлогыг бодитой төлөвлөх;
2. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор санхүүжүүлэх арга хэмжээг менежментийн төлөвлөгөөний дагуу ач холбогдлоор нь эрэмбэлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, хууль, журамд заасны дагуу зарцуулж, тайлагнах;
4. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасны дагуу нийт орлогоос хувь хэмжээгээр тооцон баталж, зарцуулж, тайлагнах.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст:

1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд Засаг даргын харьяа байгууллагуудыг мэргэжлийн арга зүй, удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах;

Байгаль орчин, аялал жуулчлалын газарт:

1. Байгалийн ургамлын менежментийн төлөвлөгөөний дагуу байгалийн ургамлын нарийвчилсан судалгаа тооллогыг гүйцэтгэж, ховор, нэн ховор ургамлын нөөцийг тогтоох, хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх;
2. Аймгийн байгалийн дурсгалт болон нөөц газар, тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах;



Шалгагдагч байгууллагын санал, тайлбар

7. баг сагт ханд
Саналыг судлахыг
таалагч гэвэл


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын
ордон, 7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас/факс: 70592353 Цахим шуудан: info@dundgovi.gov.mn
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2023. 06. 19 № 01/898
танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Танай ирүүлсэн 2023 оны 06 дугаар сарын 19-
ний өдрийн 1/74 тоот албан бичгийн дагуу байгалийн
нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн
хэрэгжилтэд хийгдсэн нийцлийн аудитын төсөлтэй
танилцлаа. Тайлангийн төсөлд санал байхгүй байна.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

4803140586



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

1-105 дугаар байр, Буяннэмэхийн өргөн чөлөө,
Залуус хороолол, 7 дугаар баг, Сайнцагаан сум,
Дундговь аймаг, 48090, Утас/Факс: (976) 7059 3988,
Цөхмөр шуудан: baigali@dundgov.gov.mn,
Цахим хуудас: <http://baigali.du.gov.mn/>

2023.06.19 № 137
танай 2023.06.19-ны № 1/75 -Т

Санал хүргүүлэх тухай

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Г.Батсайхан

Самсаныг тусгай тусгай

1/19

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийсэн тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус аудитын зөвлөмжөөр байгалийн ургамлын менежментийн төлөвлөгөөний дагуу нарийвчилсан судалгаа хийлгэхэд санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй, байгалийн нөөц ашигласны төлбөрийг ой, ургамал, амьтан, газар, ус гэсэн 5 төрлийн орлогоос бүрдэж, дээрх 5 төрөлд зарцуулах журмын зохицуулалттай. Гэтэл говийн бүс нутагт ой, ойн дагалт баялаг, ургамлаас орлого орох нөхцөл бүрдээгүй байна. Иймээс ургамлын нарийвчилсан судалгаа хийлгэхэд санхүүгийн эх үүсвэргүй хүндрэлтэй байгаа.

Иймд Монгол улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтад нэмэлт өөрчлөлт оруулж давсан орлогоор Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заалтын дагуу байгаль орчны чиглэлээр бусад зарцуулах боломжийг бий болгох саналтай байна.

ДАРГА *[Signature]* Н.ГАНТУЛГА



482302033

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сум, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ᠋ᠣᠨ